

4-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ НЭГДМЭЛ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР

2019.05.01

40 минут

А хувилбар

Монгол хэл

1. Дараах өгүүлбэрийн утгыг гаргахын тулд таслал зөв бичсэн өгүүлбэр аль нь вэ?

А. Дархан, хот руу автобусаар явлаа.

Б. Дархан хот руу автобусаар явлаа.

2. Аавдаа 50-60 үгэнд багтаан захидал бичээрэй. 5 оноо

- Ямар зорилгоор аавдаа захидал бичихээ тодорхойлоорой
- Хэдэн цогцолбортой байх, аль хэсэгт нь юуны тухай бичихээ төлөвлөөрэй
- Эхлэл хэсгийг төлөвлөх-Сайн сайхан үгтэй мэндчилгээ бичээрэй
- Гол хэсгийг төлөвлөх-Яагаад энэ захидлыг бичих болсон шалтгаан
- Төгсгөл хэсгийг төлөвлөх-Сайн сайхныг хүссэн өгүүлбэрээр төгсгөөрэй

Сайн байна уу? Хайрт аав минь

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

3. Нөхцөлийг зөв залгаж бичсэн хэсгийн дугаарыг дугуйлаарай.

А. ажлийг, өдрийг, шоргоолжоор, зөгийг

Б. ажилийг, өдрөөр, шоргоолжийг, зөгийгөөр

В. ажлыг, өдрийг, шоргоолжийг, зөгийгөөр

Г. ажлыг, өдрөөр, шоргоолжыг, зөгийг

Математик

4. (145973+655487)-235414-132468

А. 801460

Б. 433578

В. 433778

Г. 668992

5. Саальчид 1 дэх өдөр 6 хувин, 2 дахь өдөр 10 хувин сүү тушаав. 2 дахь өдөр 1 дэх өдрөөс 24 литрээр илүү сүү саасан бол саальчид 2 өдөрт хэдэн литр сүү саасан бэ?

Хүн байгаль

6. Хүний биеийн булчин нь араг ястай юугаар холбогдож хөдөлгөөнд оролцдог вэ?

А. шөрмөсөөр

Б. судсаар

В. ясаар

Г. махаар

7. Мөсийг хөргөгчнөөс гаргаж, дулаан газар тавьжээ. 1.5 оноо

Ямар өөрчлөлт болсон вэ?

.....
Энэ үзэгдлийг юу гэж нэрлэх вэ?

.....
Энэ үзэгдэлтэй ижил үзэгдлийн жишээ гаргана уу?

.....

Хүн нийгэм

8. Угийн бичигт өөрийн эцгийн эцгийг юу гэж нэрлэдэг вэ?
А. Эцэг Б.Эцгийн эцэг В. Өвөг эцэг

Эрүүл мэнд

9. Гар утсыг 8-10 насны хүүхдүүд өдөрт хэдэн цаг хэрэглэж болно гэж заасан байдаг вэ?
А. 30 минут Б. 40 минут В. 50 минут Г. 30-50 минут

Дүрслэх урлаг, технологи

10. Улаан дэвсгэр дээр нарийн зураасаар есөн эрдэнийн будгаар зурсан зургийг юу гэж нэрлэдэг вэ? Зөв дугуйлаарай.
А. Нагтан зураг
Б. Мартан зураг
В. Хөрөг зураг

4-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ НЭГДМЭЛ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР

2019.05.01

40 минут

Б хувилбар

Монгол хэл

1. Дараах өгүүлбэрийн утгыг гаргахын тулд таслал зөв бичсэн өгүүлбэр аль нь вэ?
А. Орхон аймаг руу машинаар явлаа.
Б. Орхон, аймаг руу машинаар явлаа.
2. Аавдаа 50-60 үгэнд багтаан захидал бичээрэй. 5 оноо
- Ямар зорилгоор аавдаа захидал бичихээ тодорхойлоорой
 - Хэдэн цогцолбортой байх,аль хэсэгт нь юуны тухай бичихээ төлөвлөөрэй
 - Эхлэл хэсгийг төлөвлөх-Сайн сайхан үгтэй мэндчилгээ бичээрэй
 - Гол хэсгийг төлөвлөх-Яагаад энэ захидлыг бичих болсон шалтгаан
 - Төгсгөл хэсгийг төлөвлөх-Сайн сайхныг хүссэн өгүүлбэрээр төгсгөөрэй

Сайн байна уу? Хайрт аав минь

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

3. Аль хэсэгт бүх үгийг зөв бичсэн байна вэ?
А. уншхаар, бужиганалдан, цочхоороо
Б. уншихаар, бужигналдан, цочихоороо
В. уншихаар, бужагналдан, цочхоороо
Г. уншхаар, бужиналдан, цочихоороо

Математик

4. $876345 - (654765 - 305699) + 225306$

А. 141187 Б. 527228 В. 349066 Г. 752594

5. Дэлгүүр 1 дэх өдөр 8 хайрцаг, 2 дахь өдөр 14 хайрцаг жимс худалдав. 2 дахь 1 дэх өдрөөс 30 килограммаар илүү жимс худалдав. Дэлгүүр 2 өдөрт бүгд хэдэн килограмм жимс худалдсан бэ?

Хүн байгаль

6. Хүний биеийн дотор олон тооны яс байх бөгөөд тэдгээрийг бүхэлд нь юу гэдэг вэ?

А. араг яс Б. гавлын яс В. нурууны яс Г. биеийн булчин

7. Ус буцалгахад:

✓ ямар өөрчлөлт болсон вэ?

✓ Энэ үзэгдлийг юу гэж нэрлэх вэ?

✓ Энэ үзэгдэлтэй ижил үзэгдлийн жишээ гаргана уу?

Хүн нийгэм

8. Угийн бичигт өөрийн эхийн эхийг юу гэж нэрлэдэг вэ?

А. Эх Б. Эхийн эх В. Эмэг эх

Эрүүл мэнд

9. 8-10 насны хүүхэд өдөрт компьютерийн ард суух хугацааг хэд гэж заасан байдаг вэ?

А. 10 минут Б. 15 минут В. 20 минут Г. 25 минут

Дүрслэх урлаг, технологи

10. Мартан нагтан зураг аль төрөлд хамаарагдах вэ?

А. Монгол зураг
Б. Уран зураг
В. Зураасан зураг